



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн,  
удирдамж батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2.3, 2.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуурыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 12 дугаар сард Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг (Б.Болортуяа)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний алба (Л.Оюунчимэг)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



М.ОДГЭРЭЛ

102507138753

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын  
2025 оны 11 дүгээр сарын 07 ны өдрийн  
А/ДЗ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН  
ШАЛГУУРЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Болортуяа, Тусламж, үйлчилгээний чанар,  
магадлан итгэмжлэлийн албаны дарга

Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагын  
магадлан итгэмжлэлийн шалгуур  
боловсруулах багийн нарийн бичиг:

А.Баярзаяа, Тусламж, үйлчилгээний чанар,  
магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн

Лавлагаа шатны Эрүүл мэндийн  
байгууллагын магадлан итгэмжлэлийн  
шалгуур боловсруулах багийн нарийн  
бичиг:

Б.Мөнхцэцэг, Тусламж, үйлчилгээний чанар,  
магадлан итгэмжлэлийн албаны ахлах  
мэргэжилтэн

Анхан шатны Эрүүл мэндийн  
байгууллагын магадлан  
итгэмжлэлийн шалгуур  
боловсруулах багийн гишүүд:

Л.Бор, Тусламж, үйлчилгээний чанар, магадлан  
итгэмжлэлийн албаны ахлах мэргэжилтэн

Г.Хулан, ЭМЯ, Эмнэлгийн тусламжийн бодлогын  
газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Б.Болорчимэг, Тусламж, үйлчилгээний чанар,  
магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн

Д.Мягмарцэрэн, Ерөнхий мэргэжлийн салбар  
зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Т.Алимаа, ЭТҮЧАБ мэргэжлийн салбар зөвлөлийн  
гишүүн, /зөвшилцсөнөөр/

Л.Баярцэцэг, Монголын эрүүл мэндийн чанарын  
холбоо, Гурван гал эмнэлэг /зөвшилцсөнөөр/

Ч.Дулмаа, УХТЭ, ЭМТҮЧАБА-ны чанарын менежер  
/зөвшилцсөнөөр/

Ж.Нямсүрэн, ХӨСҮТ, халдвар судлаач эмч  
/зөвшилцсөнөөр/

С.Оюунгэрэл, магадлан итгэмжлэлийн шинжээч ХӨСҮТ  
тархвар судлаач /зөвшилцсөнөөр/

Э.Долгорсүрэн, БГД ӨЭМТ-ийн эмч, /зөвшилцсөнөөр/

Лавлагаа шатны ЭМБ-ийн магадлан  
итгэмжлэлийн шалгуур  
боловсруулах багийн гишүүд:

А.Мягмарсүрэн, Тусламж, үйлчилгээний чанар,  
магадлан итгэмжлэлийн албаны мэргэжилтэн

Б.Дашдондов, ЭМЯ, Эмнэлгийн тусламжийн бодлогын  
газрын мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

Ч.Дуламрагчаа, Чанарын салбар зөвлөлийн ерөнхий  
мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

А.Оюунчимэг, ЭХЭМҮТ, ЭМТҮЧАБА-ны дарга, ЭТҮЧАБ  
мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын эрүүл  
мэндийн чанарын холбоо УЗ-ын гишүүн  
/зөвшилцсөнөөр/

Ц.Сарантуяа, Дотрын анагаах ухаан судлалын  
мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн

Б.Уранчимэг, Интермэд эмнэлэг, ЭМТҮЧАБА-ны дарга,  
ЭТҮЧАБ мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн  
/зөвшилцсөнөөр/

З.Аръяасүрэн, УХТЭ, ЭМТҮЧАБА-ны дарга, ЭТҮЧАБ  
мэргэжлийн салбарын зөвлөлийн гишүүн,  
/зөвшилцсөнөөр/

Б.Хандмаа, ТТАХНЭ, ЭМТҮЧАБА-ны дарга, ЭТҮЧАБ  
мэргэжлийн салбарын зөвлөлийн гишүүн,  
/зөвшилцсөнөөр/

Б.Баасанжав, ХСҮТ, ЭМТҮЧАБА-ны дарга, ЭТҮЧАБ  
мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн,  
/зөвшилцсөнөөр/

Д.Хулан, Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөлийн  
ерөнхий мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/

С.Ванчиндорж, Мэс заслын шинжээч, мэс заслын  
мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн  
/зөвшилцсөнөөр/


О.Янжив, Магадлан итгэмжлэлийн шинжээч, Яаралтай  
тусламжийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн  
/зөвшилцсөнөөр/

Ц.Уянга, УХТЭ, Магадлан итгэмжлэлийн шинжээч  
/зөвшилцсөнөөр/

Д.Золзаяа, АШУУИС, МЯЭ-ийн ХСХА-ны дарга,  
/зөвшилцсөнөөр/



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын  
2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн  
А/113 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

### Үндэслэл:

Эрүүл мэндийн байгууллагад хийгдэж байгаа магадлан итгэмжлэлийн үнэлгээнд Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/554 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэшсэн тусамж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур”, 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/179, А/180 дугаар тушаалаар батлагдсан “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуур”, “Сувилал, сэргээн засах болон сувилахуйн төвийг магадлан шинжлэх шалгуур” шалгуур үзүүлэлтүүдийг тус тус ашиглаж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.21-д “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төрөөс хараат бус бие даасан магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлнэ.”, 2.2.30-д “Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.” гэж заасан.

Одоогийн мөрдөж буй эрүүл мэндийн байгууллагын магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт нь 3 дэд бүлгийн хүрээнд давхцал ихтэй, хэмжих үзүүлэлтийн тоо хэт олон, орцод суурилсан, шалгуур үзүүлэлт бүрийн үнэлгээний зарчим адил байгаагаас тусламж үйлчилгээний чанарын асуудлыг илэрхийлсэн үзүүлэлтэд ялгавартайгаар оноо өгөх боломжгүй байгаа зэрэг асуудлууд тулгарч байна.

Магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтүүд батлагдсанаас хойш Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Сэргээн засах төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6801:2019, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Өрх сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний журам жагсаалт ЭМС-ын А/283 тоот тушаал, Үйлчлүүлэгчийг танин тодруулах ЭМС-ын А/352 тоот тушаал, Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх ЭМС-ын А/220 тоот тушаал, Чанар сайжруулах ажлын удирдамж, төлөвлөгөө батлах ЭМС-ын А/136 тоот тушаал зэрэг эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдсэн тул шалгуур үзүүлэлтэд тусгах зайлшгүй шаардлага гарч байна.

Олон Улсын Эрүүл Мэндийн Чанарын Нийгэмлэгийн Гадаад Үнэлгээний Холбооны /ISQuaEEA/ зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн стандарт шалгуурыг 3 жил тутамд шинэчлэн өөрчлөх зөвлөмжтэй байдаг.

Иймд Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурыг Олон Улсын Эрүүл Мэндийн Чанарын Нийгэмлэгийн Гадаад Үнэлгээний Холбооны (International Society for Quality in Healthcare External Evaluation Association - ISQuaEEA) магадлан итгэмжлэлийн стандартад тавигддаг шаардлагад нийцүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, өвчтөний аюулгүй байдал, оношилгоо, эмчилгээний технологийн хүрээнд гарсан эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах шаардлага гарсан.

Энэхүү удирдамжийн хүрээнд магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах, боловсруулсан шалгуур үзүүлэлтийг эрүүл мэндийн байгууллагад турших, оролцогч талуудаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

**Зорилго:**

Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах, хэлэлцүүлэх, турших.

**Зорилт:**

1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах
2. Шинэчлэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг хэлэлцүүлэх
3. Шинэчлэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг эрүүл мэндийн байгууллагад турших, дахин сайжруулах

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулах, ажлын төлөвлөгөөг батлуулна.
- Дэд ажлын хоёр хэсэгт хуваагдаж, магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулна.
- Боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг урьдчилсан сорил хийнэ.
- Гарсан саналыг нэгтгэн, тусгана.
- Эцэслэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг оролцогч талуудаар хэлэлцүүлнэ.
- Эцэслэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг ЭМХТ-ийн удирдлагын зөвлөл, ЭМЯ-ны магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

**Хугацаа:**

2025 оны 11-р сарын 17-оос 12-р сарын 15 хүртэл

**Хүрэх үр дүн:**

1. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанарыг гүйцэтгэлтэй нь уялдуулан магадлан итгэмжлэлийн шалгуурыг шинэчлэн боловсруулсан байна.
2. Шинэчлэгдэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг урьдчилсан сорилыг хийсэн байна.
3. Шинэчлэгдэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг оролцогч талуудыг хамруулан хэлэлцүүлсэн байна.
4. Шинэчлэгдэн боловсруулсан магадлан итгэмжлэлийн шалгуурыг ЭМХТ-ийн удирдлагын зөвлөл, ЭМЯ-ны магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна.